



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/16-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.Open.audit.mn
Архангай аймаг
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор П.Цэцэгдулам
Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Албан шаардлага	11
5.2 Зөвлөмж.....	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangaiaudit.gov.mn

2024.03.25 № 157

танай _____-ны № _____-г

АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.ЛХАГВАДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөг эс тооцвол Эрдэнэмандал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр Иргэдийн оролцоо малчдын хөгжлийг дэмжих, Малын үүлдэр угсаа сайжруулах дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр нийт 27,700.0 мянган төгрөгийг сумын ИТХ-аар баталж, тухайн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд тэмцээн уралдаан зохион байгуулж, шагнал, бэлэг дурсгалын зүйл зэрэг урсгал зардалд 9,000.0 мянган төгрөг, "Шилмэл сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны дэмжлэгт 5,700.0 мянган төгрөг нийт 14,700.0 мянган төгрөгийг ОНХС-аас зориулалт бусаар зарцуулж өмнөх аудитаас өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг дахин давтан гаргасан байна.
2. Хоршоо хөгжүүлэх сангаас шинээр байгуулагдсан "Ар саравч" ОНӨААТҮГ-т Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/56 дугаар захирамж, 202306 дугаартай зээлийн гэрээний дагуу 66,000.0 мянган төгрөгийн зээл олгосон бөгөөд тус зээлийг хувь хүний дансанд шилжүүлэн зарцуулсан.

Дээрх зөрчил нь Төрийн аудитын тухай хуулийн 42.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 1.4, 4.6, 4.7, 4.7.6 дахь заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар баталсан Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг зөрчсөн, аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 90.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,082,581.4	1,077,008.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	525,842.5	447,240.9
33	АВЛАГА	321,095.3	406,421.3
35	БАРАА МАТЕРИАЛ	235,643.6	223,346.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,057,549.5	11,118,539.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,057,549.5	11,118,539.5
39200	Биет хөрөнгө	10,713,063.5	10,776,317.5
39300	Биет бус хөрөнгө	344,486.0	342,222.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,140,130.9	12,195,548.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,518.4	76,093.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,518.4	76,093.9
41300	Өглөг	19,398.4	76,093.9
41400	Урьдчилж орсон орлого	120.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,120,612.5	12,119,454.2
51	Засгийн газрын хувь оролцоо	12,120,612.5	12,119,454.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,403,360.5	1,403,360.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	177,814.0	177,814.0
51200	Хуримтлагдсан үр дүн	10,444,583.8	10,443,425.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зерүү	94,854.2	94,854.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,140,130.9	12,195,548.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,885,463.0	3,455,575.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	719,608.6	598,257.7
110	Орлогын албан татвар	384,395.4	377,068.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	384,382.8	376,858.3
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	12.6	210.0
113	Хөрөнгийн албан татвар	244,639.0	166,007.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	90,574.2	55,181.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,468,920.2	1,094,554.2
120	Нийтлэг татварын бус орлого	9,455,320.2	1,051,854.2
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	13,600.0	42,700.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,696,934.2	1,762,763.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,525,942.6	2,800,531.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,525,942.6	2,800,531.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,892,649.0	2,763,509.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	587,793.1	589,944.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,976.7	72,091.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	643,694.9	66,502.5
2104	Хангамж, бараа материалын зардал	76,458.6	88,447.9
2105	Нормативт зардал	1,204.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,333.6	45,224.1
2107	Томилолт, зочны зардал	19,446.3	27,738.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,599.3	845,857.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	389,142.6	1,027,703.5
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,633,293.6	37,021.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,359,520.4	655,044.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,731,432.7	656,323.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,371,912.3	-1,278.4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,979,760.5	3,190,227.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	719,608.6	598,257.7
110	Орлогын албан татвар	384,395.4	377,068.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	384,382.8	376,858.3
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	12.6	210.0
113	Хөрөнгийн албан татвар	244,639.0	166,007.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	90,574.2	55,181.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	18,255.5	28,469.7
1181	Газрын төлбөр	51,676.4	14,219.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	20,642.3	12,492.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	563,217.7	829,205.7
120	Нийтлэг татварын бус орлого	563,217.7	829,205.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,696,934.2	1,762,763.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,250,948.1	2,387,830.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,250,948.1	2,387,830.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,604,406.5	2,350,809.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	579,583.6	680,962.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,055.2	97,404.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	663,291.5	119,370.2
2104	Хангамж, бараа материалын зардал	75,673.0	316,336.8
2105	Нормативт зардал	2,469.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,750.7	49,491.6
2107	Томилолт, зочны зардал	8,768.3	38,415.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,749.2	736,114.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,065.9	312,714.0
211	ХҮҮ	8,000.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,638,541.7	37,021.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	728,812.4	802,396.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	549,970.4	705,998.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	549,970.4	705,998.1
2200	Дотоод эх үүсвэрээр	549,970.4	705,998.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-549,970.4	-705,998.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-175,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	175,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	178,842.0	-78,601.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	347,000.5	525,842.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	525,842.5	447,240.9

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код :	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,310,705.8	13,310,705.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,005.0	4,005.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,314,710.8	13,314,710.8
7	Өмчид гарсан өөрчилөлт	177,814.0	177,814.0
9	Тайлант үеийн үр дүн	-1,371,912.3	-1,371,912.3
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,120,612.5	12,120,612.5
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,120,612.5	12,120,612.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	120.0	120.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,120,732.5	12,120,732.5
19	Тайлант үеийн үр дүн	-1,278.4	-1,278.4
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,119,454.2	12,119,454.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,620,835.0	2,301,956.7	318,878.3	87.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,569,036.1	1,500,321.4	68,714.7	95.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,532,014.6	1,463,299.9	68,714.7	95.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	615,750.0	589,790.3	25,959.7	95.8
210101	Үндсэн цалин	608,550.0	415,792.1	192,757.9	68.3
210102	Нэмэгдэл	-	120,385.4	(120,385.4)	
210104	Урамшуулал	-	46,412.8	(46,412.8)	
210105	Гэрээт ажлын хөлс	7,200.0	7,200.0	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,968.8	72,244.9	4,723.9	93.9
210201	Тэтгэврийн даатгал	52,338.8	50,048.6	2,290.2	95.6
210202	Тэтгэмжийн даатгал	6,157.5	5,895.0	262.5	95.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,926.0	4,716.0	210.0	95.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,231.5	1,034.2	197.3	84.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,315.0	10,551.1	1,763.9	85.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	614,291.6	599,807.8	14,483.8	97.6
210301	Гэрэл, цахилгаан	82,570.0	75,551.8	7,018.2	91.5
210302	Түлш, халаалт	471,021.6	471,021.4	0.2	100.0
210303	Цэвэр, бохир ус	60,700.0	53,234.6	7,465.4	87.7
2104	Хангамж, бараа материалын зардал	53,643.5	52,430.8	1,212.7	97.7
210401	Бичиг хэрэг	9,040.0	9,240.3	(200.3)	102.2
210402	Тээвэр, шатахуун	19,600.0	18,600.0	1,000.0	94.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000.0	6,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	1,219.8	806.8	413.0	66.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,718.4	13,718.4	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,065.3	4,065.3	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,860.0	62,934.5	11,925.5	84.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,500.0	12,900.0	600.0	95.6
210604	Урсгал засвар	61,360.0	50,034.5	11,325.5	81.5
2107	Томилолт, зочны зардал	39,558.7	34,028.5	5,530.2	86.0
210702	Дотоод албан томилолт	39,558.7	34,028.5	5,530.2	86.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,542.0	34,663.0	4,879.0	87.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,569.8	28,085.3	4,484.5	86.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,304.2	4,154.2	150.0	96.5
210803	Даатгалын үйлчилгээ	100.0	-	100.0	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	480.0	396.5	83.5	82.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	378.0	317.0	61.0	83.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,610.0	1,610.0	-	100.0
210807	Газрын төлбөр	100.0	100.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,400.0	17,400.0	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,400.0	17,400.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,021.5	37,021.5	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,021.5	37,021.5	-	100.0

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,721.5	30,721.5	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,300.0	6,300.0	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	822,853.3	626,635.3	196,218.0	76.2
223001	Бусад хөрөнгө	822,853.3	626,635.3	196,218.0	76.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	228,945.6	175,000.0	53,945.6	76.4
230001	Эргэж төлөгдөх зээл	228,945.6	175,000.0	53,945.6	76.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,620,835.0	2,172,646.6	448,188.4	82.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,993,675.5	2,012,343.3	(18,667.8)	100.9
320001	Орон нутгийн төсвөөс	1,631,261.2	1,649,929.0	(18,667.8)	101.1
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	362,414.3	362,414.3	-	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	627,159.5	160,303.3	466,856.2	25.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	239,755.6	160,303.3	79,452.3	66.9
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	387,403.9	-	387,403.9	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	331,129.8	(331,129.8)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	201,819.7	(201,819.7)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.00	3.00	0	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37.00	37.00	0	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	356,463,701.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	351,013,701.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,013,701.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,895,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,207,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,387,380.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,209,521.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	295,314,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,450,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,450,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	356,463,701.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	356,463,701.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй. Залруулагдаагүй нийт 52,872.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 14,700.0 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага 1, 38,172.8 мянган төгрөгөнд 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр Иргэдийн оролцоо малчдын хөгжлийг дэмжих, Малын үүлдэр угсаа сайжруулах дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр нийт 27,700.0 төгрөгийг ИТХ-аар баталж, тухайн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд тэмцээн уралдаан зохион байгуулж, түүний шагнал, бэлэг дурсгалын зүйл зэрэг урсгал зардалд 9,000.0 мянган төгрөг, "Шилмэл сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны дэмжлэгт 5,700.0 мянган төгрөг нийт 14,700.0 мянган төгрөгийг ОНХС-аас зориулалт бус зарцуулж өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлж, зөрчлийг дахин давтан гаргасан байна. Мөн шинээр байгуулагдсан "Ар саравч" ОНӨААТҮГ-т Хоршоо хөгжүүлэх сангаас 66,000.0 мянган төгрөгийн зээл олгосон бөгөөд тус зээлийг хувь хүний дансанд шилжүүлэн зарцуулсан.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1. Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ..., албан үүргээ биелүүлээгүй, ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төвлөрүүлэн захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

5.2.1 ОНӨААТҮГ-уудтай холбоотой

Илрүүлэлт: Суманд үйл ажиллагаа явуулж буй ОНӨААТҮГ-ууд нь жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, зардлыг эдийн засгийн үндэслэлтэй тооцож батлуулаагүй, мэдээллийн ил тод байдал, санхүү нягтлан бодох бүртгэлийг хангалтгүй хөтөлдөг, тогтвор суурьшилтай нягтлан бодогчгүй, төсөв санхүүгийн хувьд бие даагаагүй, өөрийн өөрийгөө санхүүжүүлж, үр ашигтай ажиллах үйл ажиллагааны зохион байгуулалт хангалтгүй, санхүү бүртгэл, үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаад сумын ИТХ болон ТУЗ-өөс үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1 “ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах”, 77.2.2/ “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх”, сумын ИТХ-аар баталсан ОНӨААТҮГ-уудын дүрэмтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНӨААТҮГ-уудын санхүү нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах, үйл ажиллагааг жигдрүүлэх, өөрийн өөрийгөө санхүүжүүлж үр ашигтай ажиллуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллах зөвлөмжийг сумын ИТХ-д хүргүүлэх.

5.2.2 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх санд 5 зээлдэгчтэй холбоотой 38,172.8 мянган төгрөгийн 2-10 жилийн насжилттай чанаргүй зээлийн үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авах, зээлийн хүүг авлагаар бүртгэх, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг зөвлөмжийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Өмнөх аудитаар хүргүүлсэн шийдвэрийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг дахин давтан гаргасан.	1	14700.0								1	14700.0	0	0
ХХС-ийн чанаргүй зээлийн үлдэгдэлд арга хэмжээ авч ажиллаагүй	1	38172.8					2	38172.8					
Нийт дүн	2	52872.8					2	38172.8	1	14700.0			